



**БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2015 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/193

Булган

Журам батлах тухай

Монгол улсын Засгийн газрын 1997 оны "Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай" 54 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Аймгийн Засаг даргын шагналын журам"-ыг нэгдүгээр, аймгийн Засаг даргын шагналаар шагнуулах иргэний тодорхойлолтын загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шагналын дагалдах мөнгөн шагналыг иргэний харьяалах сум, байгууллагын төсвөөс гаргаж байхыг сумын Засаг дарга, байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны А111 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА




Д.ЭРДЭНЭБАТ

20150141

11/193

Аймгийн Засаг даргын 2015 оны
...дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Булганхангай нутгийг хөгжүүлэх үйлсэд үр бүтээлтэй ажиллаж, онцгой амжилт гаргасан иргэн, байгууллагын хувь нэмрийг үнэлж, урамшуулж, алдаршуулахад энэ журмын зорилго оршино.

Хоёр. Аймгийн Засаг даргын шагнал.

1. Аймгийн “Хүндэт иргэн”
2. Аймгийн “Тэргүүний ажилтан” тэмдэг
3. Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”
4. Аймгийн Засаг даргын “Баярын бичиг”
5. Аймгийн “Оны шилдэг ажилтан” өргөмжлөл
6. Аймгийн “Оны тэргүүний сум” өргөмжлөл
7. Аймгийн “Оны шилдэг агентлаг” өргөмжлөл
8. Аймгийн “Оны тэргүүний хамт олон” өргөмжлөл
9. Аймгийн “Оны шилдэг хүүхэд” өргөмжлөл
10. Аймгийн “Оны хүүхдэд ээлтэй байгууллага” өргөмжлөл
11. Аймгийн “Тэргүүний хилчин” өргөмжлөл
12. Аймгийн “Тэргүүний ахмад” өргөмжлөл
13. Аймгийн “Шилдэг бүтээн байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ” өргөмжлөл
14. Аймгийн “Сайн малчин” тэмдэг
15. Аймгийн “Тэргүүний тариаланч, тариаланч хамт олон” өргөмжлөл, тэмдэг
16. Аймгийн “Тэргүүний малчдын хоршоо, бүлэг” өргөмжлөл
17. Аймгийн “Тэргүүний фермер” өргөмжлөл
18. Аймгийн “Алдарт уяач” цол

Гурав. Шагнал олгох журам

1. Аймгийн Засаг даргын шагналаар шагнагдах иргэнийг харьяалах багийн Засаг дарга, байгууллага, төрийн бус байгууллага тодорхойлж, материалыг аймгийн Засаг даргын Тамгын газар, сумын Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, газрын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, аймгийн Засаг даргад уламжилна.

2. Аймгийн шагналаар Үндэсний их баяр наадам, Цагаан сар зэрэг бүх нийтийн тэмдэглэлт баярын өдөр, аймаг, сум байгуулагдсаны тэгш ойн баяр, салбарын тэмдэглэлт ойн үеэр шагнана.
3. Аймгийн хөгжилд дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаад иргэнийг аймгийн шагналаар шагнаж болно.
4. Аймгийн **“Хүндэт иргэн”-ээр** шагнах асуудлыг аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан тусгайлсан журмыг баримтлан шийдвэрлэнэ.
5. Аймгийн **“Тэргүүний ажилтан”** тэмдгээр дараах шалгуурыг хангасан иргэнийг шагнана.
 - А. Булган аймгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, улсад 10-аас дээш жил ажилласан байх
 - Б. Эрхэлсэн ажилдаа сүүлийн 3-аас доошгүй жил тогтвортой амжилт гаргаж, салбарын хэмжээнд аймгийн дээд амжилт, болзол шалгуур хангасан байх.
 - В. Ажлын үр дүнг дээшлүүлэх талаар тодорхой санаачилга гаргаж хэрэгжүүлсэн байх
 - Г. Аймгийн Засаг даргын **“Жуух бичиг”-ээр** шагнагдсанаас хойш 3-аас доошгүй жил аймгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж ажилласан байх
6. Аймгийн Засаг даргын **“Жуух бичиг”-ээр** дараах шалгуурыг хангасан иргэнийг шагнана.
 - А. Булган аймгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, улсад 5-аас дээш жил ажилласан байх
 - Б. Эрхэлсэн ажилдаа сүүлийн 3-аас доошгүй жил тогтвортой амжилт гаргаж, тодорхой үр бүтээл гаргасан байх.
 - В. Ажлын үр дүнг дээшлүүлэх талаар тодорхой санаачилга гаргаж хэрэгжүүлсэн байх
7. Аймгийн Засаг даргын **“Баярын бичиг”-ээр** дараах шалгуурыг хангасан иргэнийг шагнана.
 - А. Булган аймгийн хөгжилд хувь нэмрээ оруулж өндөр амжилт гаргасан байх
 - Б. Эрхэлсэн ажилдаа тогтвортой үр бүтээл гаргаж, аймаг, бүсийн хэмжээнд үнэлэгдсэн байх
8. Аймгийн шагналаар шагнуулах иргэний тодорхойлолт, материал дараах зүйлээс бүрдэнэ.
 - А. Шагнуулах иргэний тодорхойлолт
 - Б. Тухайн иргэнийг шагнуулах талаар хэлэлцсэн хэлтэс, газрын зөвлөл, сумын Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл

В."Тэргүүний ажилтан" тэмдэгээр шагнуулах тохиолдолд "Жуух бичиг"-ын ^{шүг} хуулбарыг тодорхойлолтод хавсаргасан байх


9. Аймгийн "Тэргүүний хамт олон", "Тэргүүний сум", "Шилдэг агентлаг", "Шилдэг агентлаг", "Оны шилдэг ажилтан", "Оны шилдэг хүүхэд", "Оны хүүхдэд ээлтэй байгууллага", "Тэргүүний хилчин", "Тэргүүний ахмад", "Шилдэг бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, үйлчилгээ", "Сайн малчин", "Тэргүүний тариаланч, тариаланч хамт олон", "Тэргүүний малчдын хоршоо, бүлэг", "Тэргүүний фермер", "Алдарт уяач"-ийг тусгай болзол, журмын дагуу шалгаруулж шийдвэрлэнэ.
10. Аймгийн Засаг даргын шагнах байгууллага, иргэний тодорхойлолтыг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн хүлээн авч хянан болзол шалгуурыг хангасан иргэдийг шагнуулах саналыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, хэлэлцүүлж, аймгийн Засаг дарга шийдвэр гаргана. Болзол шалгуур хангаагүй иргэний материалыг тодорхойлсон байгууллагад буцаан хүргүүлнэ.
11. Аймгийн Засаг даргын шагналаар шагнагдсан иргэний судалгаа, мэдээллийн санг аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн эрхлэн хөтлөнө.
12. Шагналыг аймгийн Засаг дарга гардуулна. Засаг даргын зөвшөөрснөөр аймгийн Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, сумын удирдлага ёслол хүндэтгэлийг баримтлан гардуулна.
13. Шагнагдсан иргэний дагалдах мөнгөн шагналыг харьяалах байгууллага, тодорхойлсон байгууллага, сум, байгууллагын төсвийн зардлаас гаргана.
14. Аймгийн шагналыг нэхэн олгохгүй, гээгдүүлсэн болон үрэгдүүлсэн байдлыг харгалзан нөхөн олгож болно.
15. Аймгийн шагналын загварыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Дөрөв. Дагалдах мөнгөн шагналын хэмжээ.

№	Шагналын нэр	Дагалдах зүйл, мөнгөн шагнал
1	Аймгийн "Тэргүүний ажилтан" тэмдэг	Тэмдэг, үнэмлэх, 40000 төгрөг
3	Аймгийн Засаг даргын "Жуух бичиг"	"Жуух бичиг", 30000 төгрөг
4	Аймгийн Засаг даргын "Баярын бичиг"	"Баярын бичиг", 20000 төгрөг


4193

Аймгийн Засаг даргын 2015 оны
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



АЙМГИЙН ШАГНАЛААР ШАГНУУЛАХААР ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХҮНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

20... оны ... дугаар сарын ... өдөр



1. Эцэг /эхийн/ нэр, нэр
2. Төрсөн он
3. Регистрийн дугаар
4. Эрэгтэй, эмэгтэй
5. Хэдээс хэдэн онд хаана, ямар сургууль төгссөн, боловсрол, мэргэжил,
6. Үндсэн захиргаа
7. Эрхэлж байсан ажил, албан тушаал /ажилд анх орсноосоо эхлэн он

дарааллаар нь бичнэ/:

№	Ажлын газрын нэр	Хугацаа /Хэдээс хэдэн онд/	Эрхэлсэн ажил
1.			
2.			
3.			

8. Улсад ажилласан нийт хугацаа ___/жил/, үүнээс тухайн албан тушаалд ___ жил

9. Урьд нь шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд
1		
2		
3		

10. Одоо шагнуулах гэж буй үндэслэл: /Аймгийн хөгжил, дэвшилд оруулсан зүтгэл,

байгууллагын өмнө тавигдсан зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд оруулсан бодит хувь нэмэр, зохион байгуулсан ажил, гаргасан санаачилгын тодорхой үр дүн зэргийг тусгана./

11. Ажлын гол үзүүлэлт:

№	Ажлын үзүүлэлт	20... он	20... он	20... он	20... он	20... он

12. Шагнуулахаар нэр дэвшүүлж байгаа хүний иргэний үндсэн болон журамт үүргийн хэрэгжилтийн талаарх үнэлэлт дүгнэлт. (Үндсэн оршин суугаа багийн Засаг дарга гарын үсэг зурж, тэмдэг дарна)

..... багийн Засаг дарга /...../
Гарын үсэг нэр

13. Үндсэн байгууллага, нэгжийн саналын үндэслэл:

(Үндсэн байгууллагын дарга, захирал, эрхлэгч гарын үсэг зурж, тэмдэг дарна)

..... байгууллагын дарга, эрхлэгч, төрийн бус байгууллагын тэргүүн
/...../
Гарын үсэг нэр

14. Шагналд нэр дэвшигчийг уламжилсан байгууллага, албан тушаалтны санал, тодорхойлолт (Гарын үсэг, тамга, тэмдэг дарна)

..... сумын Засаг дарга /хэлтэс, газрын дарга /...../
Гарын үсэг нэр

-----oOo-----